



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.05.21

№ 12

Асуулт тавих тухай

Монгол Улсын Их Хурлын НББХ-ны 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05.06 дугаар тогтоолоор хэд хэдэн чиглэл өгсөн байдаг. Үүнд:

Нэг. “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн хэлбэрт бүрэн шилжүүлэх”,

Хоёр. “Эмнэлгүүдийн бие даасан төсвөө захиран зарцуулах боломжийг зохих журмын дагуу бүрдүүлэх замаар, эмч ажилчдын цалин хөлсийг гүйцэтгэлд нь суурилан нэмэгдүүлэх” тухай билээ.

Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчидтай хийсэн уулзалтын үеэр эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн тогтолцоонд шилжсэн нь сайшаалтай боловч хэрэгжилтийн явцад зарим алдаа гарч байгаа талаар хэлсэн юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т тус тус заасныг үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Эмч, эмнэлгийн ажилчдад ур чадварын нэмэгдлийг олгох шалгуур, түүнийг зохицуулах эрх зүйн акт байгаа эсэх;
2. Нэг эмчийн өдөрт үзэх хүний тоо, нээх өвчтөний түүхийн норм байдаг эсэх, үүнтэй холбоотойгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээний “гүйцэтгэл” гэдэгт юуг ойлгох талаар;
3. Сум, тосгоны өрхийн эрүүл мэндийн төвийн “Үндсэн үйл ажиллагаа” зардлын зориулалт дээр хуваарилсан төсвөөс эмч, ажилчдын ур чадварын нэмэгдлийг шилжүүлэн тооцох боломж бий эсэх талаар хариу мэдээллийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Д.БАТЛУТ

ТУС3764 9023051393 9087184

20240521-8